**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА**

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Улсын бүртгэлийн хэлтсийн** 2021 **оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**Аудитын код: ХОА**-2022/17/**НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Ховд хот<br>2022 он | Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 70433061<br>Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас:70432545<br>Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn<br>Аудитор: Ц.Гантулга<br>Утас: 70432545<br>цахим хаяг: gantulga.ts @audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ... 3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ... 3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ... 4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ... 5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ... 6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ... 7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ... 9
3. Аудитын тайлан ... 9
3.1 Ерөнхий зүйл ... 9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ... 10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ... 10
3.4 Материаллаг байдал ... 10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ... 11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ... 11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ... 12
3.8 Аудитын гол асуудал ... 12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ... 12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ... 12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ... 12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ... 13
4. Аудитын илрүүлэлт ... 13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ... 14


### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| НА | Нотлох ажил |

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2022.02.25 № 2/69
танай ______-ны №______-т

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА С.ХОРОЛСҮРЭН ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

021020133

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **55,430,221.08** | **53,003,919.81** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 562,994.30 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 00.00 | 562,994.30 |
| **3121** | **Төгрөг** | 00.00 | 562,994.30 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 00.00 | 562,994.30 |
| **33** | **АВЛАГА** | 86,076.02 | |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 86,076.02 | |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 55,344,145.06 | 52,440,925.51 |
| **351** | **Түүхий эд материал** | 23,319,346.35 | 11,705,626.80 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 23,319,346.35 | 11,705,626.80 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 4,136,190.00 | 4,151,190.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 27,888,608.71 | 36,584,108.71 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,128,500.00 | 2,235,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 24,760,108.71 | 34,348,608.71 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **29,328,256.36** | **173,964,837.99** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 29,328,256.36 | 173,964,837.99 |
| **392** | **Биет хөрөнгө** | 29,328,256.36 | 173,964,837.99 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 14,100,000.00 | 14,100,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -4,230,000.00 | -7,050,000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 231,950,057.65 | 292,329,527.65 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -223,764,508.77 | -133,171,900.18 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 43,619,970.00 | 43,619,970.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -32,347,262.52 | -35,862,759.48 |
| 39301 | Програм хангамж | 5,419,900.00 | 5,419,900.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -5,419,900.00 | -5,419,900.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **84,758,477.44** | **226,968,757.80** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **562,994.30** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 562,994.30 |
| **414** | **Урьдчилж орсон орлого** | 00.00 | 562,994.30 |
| 41410 | Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв | 00.00 | 562,994.30 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **84,758,477.44** | **226,405,763.50** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 84,758,477.44 | 226,405,763.50 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 84,758,477.44 | 226,405,763.50 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 84,758,477.44 | 90,077,145.33 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 136,328,618.17 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **84,758,477.44** | **226,968,757.80** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **759,610,471.53** | **853,978,340.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 26,142,171.53 | **219,259,340.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 26,142,171.53 | 219,259,340.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 26,142,171.53 | 219,259,340.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 26,142,171.53 | 219,259,340.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 733,468,300.00 | **634,719,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 572,658,800.00 | 545,867,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 572,658,800.00 | 545,867,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 160,809,500.00 | 88,851,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 160,809,500.00 | 88,851,500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **762,771,949.03** | **717,649,721.83** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **762,771,949.03** | **717,649,721.83** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 762,771,949.03 | 717,294,521.83 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 470,905,550.62 | 448,254,143.91 |
| 210101 | Үндсэн цалин | 435,836,750.62 | 377,487,715.91 |
| 210102 | Нэмэгдэл | 30,184,800.00 | 60,876,328.92 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,884,000.00 | 9,890,099.08 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 61,716,007.22 | 69,447,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 38,727,313.37 | 51,959,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,639,691.83 | 4,372,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,794,131.06 | 3,497,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,141,569.18 | 874,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,413,301.78 | 8,744,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 14,394,100.00 | 13,546,900.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 362,200.00 | 291,200.00 |
| 210302 | Түлш, халаалт | 2,818,100.00 | 3,047,700.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,245,000.00 | 208,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 8,968,800.00 | 10,000,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 22,741,798.00 | 18,788,200.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 13,192,011.00 | 9,551,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,856,800.00 | 5,487,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,661,687.00 | 1,976,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 31,200.00 | 42,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,000,100.00 | 1,729,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,352,938.90 | 34,698,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 697,200.00 | 863,300.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,525,738.90 | 32,426,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 130,000.00 | 1,408,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 13,501,346.80 | 24,634,089.55 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 650,000.00 | 481,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 432,000.00 | 280,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 120,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 82,429.00 | 120,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 12,314,917.80 | 23,611,089.55 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 172,214,858.35 | 107,925,388.37 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 160,806,501.00 | 88,851,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 962,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 11,408,357.35 | 18,111,888.37 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 516,000.00 | 355,200.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 516,000.00 | 355,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 516,000.00 | 355,200.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3,333,349.14 | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,330,350.14 | |
| 213306 | Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх орлого | 2999.00 | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-3,161,477.50** | **136,328,618.17** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-3,161,477.50** | **136,328,618.17** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 00.00 | 00.00 | 87,919,954.99 | 87,919,954.99 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **87,919,954.99** | 87,919,954.99 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 8,675,341.93 | 8,675,341.93 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **84,758,477.44** | 84,758,477.44 |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **84,758,477.44** | 84,758,477.44 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 5,318,667.89 | 5,318,667.89 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **90,077,145.33** | 90,077,145.33 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 136,328,618.17 | 136,328,618.17 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **226,405,763.50** | 226,405,763.50 |

## 2.4 **Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **878,088,574.00** | **850,912,555.86** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **144,620,274.00** | **216,193,555.86** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 144,620,274.00 | 216,193,555.86 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 144,620,274.00 | 216,193,555.86 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 144,620,274.00 | 216,193,555.86 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **733,468,300.00** | **634,719,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 572,658,800.00 | 545,867,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 572,658,800.00 | 545,867,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 160,809,500.00 | 88,851,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 160,809,500.00 | 88,851,500.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **878,088,574.00** | **850,349,561.56** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **878,088,574.00** | **850,349,561.56** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **729,618,950.86** | **634,363,800.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 451,527,897.68 | 442,849,400.00 |
| 210101 | Үндсэн цалин | 378,913,249.68 | 372,082,972.00 |
| 210102 | Нэмэгдэл | 62,384,148.00 | 60,876,328.92 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,230,500.00 | 9,890,099.08 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 81,179,736.18 | 69,447,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 64,688,381.52 | 51,959,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,135,342.20 | 4,372,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,307,872.94 | 3,497,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 820,372.71 | 874,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,227,766.81 | 8,744,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 14,394,100.00 | 13,546,900.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 336,000.00 | 291,200.00 |
| 210302 | Түлш, халаалт | 2,818,100.00 | 3,047,700.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 240,000.00 | 208,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 11,000,000.00 | 10,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 17,661,687.00 | 14,845,200.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,726,900.00 | 5,608,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,808,800.00 | 5,487,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,867,187.00 | 1,976,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 31,200.00 | 42,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,227,600.00 | 1,729,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,796,600.00 | 2,838,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 800,200.00 | 863,300.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 866,400.00 | 566,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 130,000.00 | 1,408,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,156,429.00 | 1,023,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 620,000.00 | 481,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 432,000.00 | 280,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 120,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 82,429.00 | 120,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 160,806,501.00 | 89,813,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 160,806,501.00 | 88,851,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 962,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **148,469,623.14** | **215,985,761.56** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 516,000.00 | 355,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 516,000.00 | 355,200.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 147,953,623.14 | 215,630,561.56 |
| 213306 | Төвлөрүүлэх шилжүүлэг улсын төсөв | | 215,630,561.56 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **562,994.30** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 562,994.30 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 562,994.30 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/ төгрөгөөр /**

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 545,867,500.00 | 545,867,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 545,867,500.00 | 545,867,500.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 545,512,300.00 | 545,512,300.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 442,849,400.00 | 442,849,400.00 |
| 210101 | Үндсэн цалин | 372,083,000.00 | 372,082,972.00 |
| 210102 | Нэмэгдэл | 60,876,300.00 | 60,876,328.92 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,890,100.00 | 9,890,099.08 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 69,447,500.00 | 69,447,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 51,959,500.00 | 51,959,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,372,000.00 | 4,372,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,497,600.00 | 3,497,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 874,400.00 | 874,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,744,000.00 | 8,744,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 13,546,900.00 | 13,546,900.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 291,200.00 | 291,200.00 |
| 210302 | Түлш, халаалт | 3,047,700.00 | 3,047,700.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 208,000.00 | 208,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 10,000,000.00 | 10,000,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 14,845,200.00 | 14,845,200.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,608,800.00 | 5,608,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,487,600.00 | 5,487,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,976,500.00 | 1,976,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 42,500.00 | 42,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,729,800.00 | 1,729,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,838,300.00 | 2,838,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 863,300.00 | 863,300.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 566,700.00 | 566,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,408,300.00 | 1,408,300.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,023,000.00 | 1,023,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 481,000.00 | 481,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 280,000.00 | 280,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 120,000.00 | 120,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 120,000.00 | 120,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 962000.00 | 962000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 962,000.00 | 962,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 355200.00 | 355200.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 355,200.00 | 355,200.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 355,200.00 | 355,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 545,867,500.00 | 545,867,500.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 545,867,500.00 | 545,867,500.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 545,867,500.00 | 545,867,500.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 0.00 | 0.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 0.00 | 0.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0.00 | 0.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 41 | 41 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 32 | 32 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 4 | 4 |
| 620004 | Гэрээт ажилтан | 4 | 4 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх он** | **Гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **160809500** | **88851500** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 160809500 | **88851500** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 160809500 | 88851500 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 160809500 | 88851500 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 160809500 | 88851500 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **160809500** | 88851500 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 160809500 | 88851500 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 160809500 | 88851500 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **0** | **0** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

# 3. Аудитын тайлан

## 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал

татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шатахууны зарцуулалт, Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор Ц.Гантулга 2022 оны 02 дүгээр сарын 12-ноос 2022 оны 02 дугаар сарын 24-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25 -ны өдрийн 50 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

**3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Тус хэлтэс нь Монгол улсын "Төрийн үйлчилгээг ард иргэдэд шударга, ил тод шуурхай хүргэж, төр иргэнийг холбосон бүртгэлийн үйлчилгээгээр иргэний үүргийг дээшлүүлж эрхийг хангах" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:
*Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор "төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай"*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор Улсын бүртгэлийн Ерөнхий газрын дотоод аудитаас тус байгууллагад дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна. 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлын гүйцэтгэлд Төрийн Аудитын байгууллагаас аудит хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 **САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 **Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 545.8 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 5.4 сая төргөг төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн

материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4.3 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 **Санхүүгийн тайлангийн тодруулга**

Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 142.2 сая төгрөгөөр буюу 2.6 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эцэст 0.5 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Оны эхэнд авлага 0.08 сая төгрөг, тайлант он эцэст авлагын үлдэгдэлгүй байна. ТАйлант хугацаанд өмнөх онуудыг татварын хэлтсээс авах авлагыг бүртгээгүйтэй холбоотойгоор нэмэгдсэн 5.3 сая төгрөгийн авлагыг барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 55.3 сая төгрөг байснаас тайлант хугацаанд тусгай зориулалттай материал, бичиг хэргийн материал, аж ахуйн материал, сэлбэг хэрэгсэл,түлш шатахуун тослох материал, хүнсний материал, бусад хангамжийн материалуудыг 15 сая төгрөгөөр худалдан авсан, үнэ төлбөргүйгээр 56.5 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 74.5 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 52.4 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө оны эхэнд 295.1 сая төгрөг, тайлант онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А-1/1694 тоотоор 162.7 сая төгрөгөөр техник тоног төхөөрөмж/ компьютер, хурууны хээ уншигч, принтер, дижитал камер/ хандиваар авч, мөн дээрх газрын 2021 оны 12 дугаар сарын 10 -ны өдрийн 720 тоот тогтоолоор 102.4 сая төгрөгийн хуучирсан техник тоног төхөөрөмжийг акталж 18.1 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноор жилийн эцэст 174.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 84.8 сая төгрөг байсан ба оны эцэст 90.1 сая төгрөг болж үр дүнтэй холбоотойгоор 5.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү 5.3 сая төгрөгийн бичилт хийгдсэн байна. Энэ нь Өмнөх тайлангийн хугацаанд байгууллагаас авах авлагыг бүртгээгүйтэй холбоотой 5.3 сая төгрөгийн залруулга хийсэнтэй холбоотой ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл (-90.0) сая төгрөг болсон байна.

3.6 **Төсвийн төлөвлөлт**, **гүйцэтгэл**, **нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 **Төсвийн төлөвлөлт**

Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг оны эхэнд үндсэн үйл ажиллагааны зардалд 545.8 сая төгрөгөөр батлуулсан. Монгол улсын ЗГ-ын 43 дугаар тогтоолын1-“... эрүүл мэнд , онцгой байдал,мэргэжлийн хяналт, гааль болон **төрийн тусгай чиг үүргийн байгууллагаас** бусад...” гэсэн заалтад хамаардаг тул төсөвт тодотгол хийгдээгүй байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 545.8 сая төгрөгөөр батлан ирүүлжээ.

3.6.2 **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд улсын төсвөөс 545.8 сая төгрөг, өөрийн орлогоор 216.2 сая төгрөг,сонгуулийн зардал 88.8 сая төгрөг нийт 850.8 сая төгрөг зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 545.8 сая үйл ажиллагаанд зарцуулсан байна. Мөн үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 216.2 сая төгрөгөөр буюу 135.1 хувиар биелүүлж энэ орлогыг Улсын бүртгэлийн ерөнхий газарт төвлөрүүлж, 88.8 сая төгрөгийг сонгуулийн үйл ажиллагаанд бүрэн зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтэрсэн хэмнэсэн зардал байхгүй байна

3.6.3 **Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт данснаас 2021 оны Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулахтай холбоотой 88.8 сая төгрөгийг зарцуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

**3.8 Аудитын гол асуудал**

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 **Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 149 мэдээллийг хугацаандаа оруулсан,2 мэдээллийг хугацаа хоцруулж мэдээлсэн байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн, худалдан авах ажиллагааны зардал байхгүй байна.Ус гэрэл цахилгаан, дулаан, ашигтай квадрат метрийн талбайн хөл зэргийн аймгийн ЗДТГ-тай гэрээ байгуулан түрээс төлдөг байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан бараа материал, үнэт цаасны тооцоо бодолтой холбоотой 2 зөвлөмж, төрийн албан хаагчийн өндөр насны тэтгэвэрт гарах үеийн амралтын мөнгөний зөрүү, нэг удаагийн олгогдох тэтгэмж, цалингийн

урьдчилгаа суутгаагүй зэрэгтэй холбоотой 6.6 сая төгрөгийн төлбөрийн актыг бүрэн барагдуулж, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 **Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар элэгдлээ нөхсөн үндсэн хөрөнгийн ашиглалтын асуудалд анхаарах шаардлагатай.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 37.5 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд 37.5 сая төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

4.1 **Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн гүйлгээний мэдээллийг хугацаа хоцруулж мэдээлснийг аудитын явцад залруулав.

**4.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ***Шатахууны зарцуулалттай холбоотой асуудал***

*1.1 Илрүүлэлт:* Нягтлан бодогчийн хяналтгүйгээр зөвхөн байгууллагын даргын зөвшөөрлөөр олгодог, жолоочийн тооцооны хуудсыг жолооч нар тухайн сар бичиж тооцоо бодуулдаггүйтэй холбоотой 3.2 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог, 13 дугар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтдаа бензиний зөвшөөрөл олгох бичгийг тусган албажуулж нягтлан бодогч, нярав нарын хяналтаар олгож хэвших

2. ***Бараа материалын ашиглалттай холбоотой асуудал***.

*2.1 Илрүүлэлт*: Дансанд бүртгэлтэй байгаа 60 нэр төрлийн 34.3 сая төгрөгийн бараа материал цаашид ашиглагдах боломжгүй байгааг байгууллагын өмч хамгаалах комиссын зүгээс ажил зохион байгуулж арга хэмжээ авалгүй олон жил тайланд тусгагдан өдий хүрсэн нь *Төсвийн тухай 7 дугаар зүйлийн 37.1.7-д"Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох хуулийн холбогдох дансанд бүртгэх,тайлагнах",20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр дүнг шийдвэрлэх,...тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” хуулийн заалт, “Үнэн зөв байдал”, ”Иж бүрэн” байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Улсын бүртгэлийн хэлтэс | 2 | 37.5 | | | | | | | 2 | 37.5 |

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**